



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/73

Бүрэн сум

Гал түймрийн аюулаас урьдчилан
сэргийлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, иутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хаврын улирлын хуурайшилт эхэлж, сумын иутаг дэвсгэрт ахуйн гал түймрийн тохиолдлууд гарч байгаатай холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2.Арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Сумын төвийн айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагуудын цахилгааны утсанд үзлэг шалгалт хийж, чанарын шаардлага хангасан цахилгааны утас, хамгаалалтын бүрээс бэлтгүүлэн, илэрсэн зөрчлийг 7 хоногийн хугацаанд арилгуулж ажиллахыг Эрдэнэт Булган Цахилгаан түгээх станц Хархорин салбарын Бүрэн хэсгийн техникч (Ц.Даваадорж), байцаагч монитор (Ц.Баасанболд) нарт үүрэг болгосугай.

4.Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангаж, нөөц бүрдүүлэн, иргэдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэн цахим болон гарын авлага хэлбэрээр хүргэж ажиллахыг Шуурхай штабын дарга (Б.Отгонхшигт)-д үүрэг болгосугай.


5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Пүрэв-Очир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.ГҮВШИНБАТ



412305169

Сумын Засаг даргын 2023 оны...⁰³ дугаар
сарын ²⁷... ны өдрийн ^{17/23}... дугаар
захирамжийн хавсралт



ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажил	Хамрах хүрээ	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Айл өрхүүд, ААН, байгууллагуудын цахилгааны утсанд үзлэг хийнэ.	Айл өрхүүд, ААН, байгууллагууд	3-р сарын 27-28	техникч Ц.Даваадорж, байцаагч монитор Ц.Баасанболд
2.	Илэрсэн зөрчлийн мэдээллийг нэгтгэж судалгаа гаргана.	Айл өрхүүд, ААН, байгууллагууд	3-р сарын 27-28	техникч Ц.Даваадорж, байцаагч монитор Ц.Баасанболд
3.	Зөрчил илэрсэн айл өрх, ААН, байгууллагуудад мэдэгдэл өгч, чаиарын шаардлага хайгасан цахилгааны утас, хамгаалалтын бүрээс бэлтгүүлнэ.	Айл өрхүүд, ААН, байгууллагууд	3-р сарын 29	техникч Ц.Даваадорж, байцаагч монитор Ц.Баасанболд
4.	Авчирсан утаснуудыг солино.	Айл өрхүүд, ААН, байгууллагууд	3-р сарын 30-аас 4 дүгээр сарын 1	техникч Ц.Даваадорж, байцаагч монитор Ц.Баасанболд
5.	Иргэдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэн цахим болон гарын авлага хэлбэрээр хүргэнэ.	Иргэд, ААН, байгууллагууд	3-р сарын 27-оос 4 дүгээр сарын 1	Б.Отгонхишигт Л.Цэрэндулам
6.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж Засаг даргад ирүүлнэ.	Хариуцсан алба хаагчид	3-р сарын 22	Б.Отгонхишигт